

Монгол болон Монгол Зөвлөлтийн харилцааны талаарх Францад хийсэн судалгаа

Лаура Николов

Франц хэлэнд харилцаа хэмээх үгийг харилцан нэгэндээ нөлөөлж, нэгнээсээ хамаарах холбоо хэмээн тодорхойлдог¹. Тийм болохоор улс төрийн хоёр нэгжийн харилцааг судлахын тулд тэдний хоорондын харилцаа холбоонд үнэлэлт, дүгнэлт өгч, бие биедээ хэрхэн харилцан нөлөөлсөн болохыг судлах шаардлагатай юм. Зөвлөлт-Монголын харилцааг судлахад эхлээд аль алиных нь түүхтэй танилцахаас гадна оршин байх бүс нутгийн хүрээг судлах хэрэгтэй юм. Чингэхэд: судалж буй хоёр нэгж маань олон улсын тавцанд харилцан адилгүй нөлөө үзүүлдэг тул Европын зүгээс өгөх ач холбогдол нь ч өөр болохыг хамгийн түрүүнд мэдэх боломжтой. Ийм тохиолдолд хоорондоо тэс өөр баримт материал ашиглан, энэ сэдэв дээр хэрхэн ажиллах вэ? гэсэн асуулт зүй ёсоор гарч ирнэ. Эхний ээлжинд холбогдох баримтыг цуглуулсны дараа баримтуудаа Франц, Английн тухайн үеийн түүхийн судалгааны бүтээлүүдтэй харьцуулж үзэн Францын судалгаа шинжилгээний салбарт Бүгд Найрамдах Монгол Ард улсын талаарх судалгаа ямар байр суурь эзэлдэг, түүнчлэн ЗХУ болон БНМАУ-ын харилцааг хэрхэн үздэгийг харуулах нь зүйтэй болой.

1. Энэ хоёр улс төрийн нэгжид хамаатай харилцан адилгүй баримт сэлт

ЗХУ-ын олон улсын тавцанд эзлэх байр суурь, ялангуяа дэлхийн нэгдүгээр дайн дуусахаас ч өмнө Европын хүчирхэг гүрнүүд газар нутагт нь шохоорхож байсан зэргээс үүдээд ЗХУ-ын талаарх баримт сэлт, данс хараа асар баялаг байдаг. Франц, Английн аль ч архиваар орсон тус улсын гадаад, дотоод бодлого, эдийн засаг, улс төр, цэрэг зэвсгийн байдлын талаарх сан хөмрөг арвин их. Харин Ар Монгол, хожим БНМАУ гэгдэх улсын талаарх баримт материалыг аваад үзвэл байдал шал өөр юм.

Англи, Францын аль алиных нь архивын баримт сэлтээс үзэхэд Монгол гэдэг үг Ар, Өвөр Монголыг хоёуланг нь багтаасан нэг ойлголт юм. Энэ нь тус орны талаарх ойлголт хангалтгүй болохыг харуулах бөгөөд аливаа тэмдэглэл бичихдээ эхэнд нь заавал энэ орны талаар товч танилцуулга, түүхэн чухал үйл явдлын он сарыг дурдах шаардлага

¹ 2007 оны Жижиг Роберт словарь (франц хэл)

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

гардаг нь үүний нотолгоо билээ. Тэгээд ч үйл явдал, тэдгээрийн он сар ихэнхдээ ташаа буюу баримжаалсан байдаг.

Ар-Монголын талаарх Францын архивын хэрэглэгдэхүүн нь ерөнхийдөө Хятадын тухай баримтууд дунд байдаг. Британийн архивуудад Монголын талаарх баримт сэлт нь Хятад, ЗХУ-ын талаарх баримт данс хараануудтай хамт байдаг бөгөөд зөвхөн нэг л материал Японыхтай хамт ангилагдсан байдаг². Яагаад ингэж ангилсныг олон талаар тайлбарлаж болно. Үүнд: Ар-Монгол нь хууль ёсоор 1911 онд тусгаар тогтнолоо тунхагласан боловч Хятад улс 1946 он хүртэл хүлээн зөвшөөрөхгүй байсан юм. Тийм учраас Монголтой холбоотой баримтуудын ихэнхийг хятадынхтай хамт ангилжээ. Бодит байдлаас нь авч үзэхэд ЗХУ, Монголын харилцааны ач холбогдолтой холбон ЗХУ-ын талаарх баримтууд, ялангуяа ЗХУ-ын Ази дахь гадаад бодлогын тухай баримтуудтай хамт Монголын талаарх зарим материалыг хийжээ. Мөн ийм үндэслэлээр зарим баримтыг Японы гадаад бодлоготой холбоотой материалууд, ялангуяа 1930 он буюу Япон улс Азид газар нутгаа тэлэх үйл ажиллагаа эхэлсэн тэр үеийн баримтуудад хавсаргажээ.

Францын архивууд материалуудаа ийнхүү ангилсныг Улаанбаатар хотод дипломат төлөөлөгчийн газаргүй, БНМАУ-тай харилцаа холбоогүй байсантай холбон тайлбарлаж болох юм. Чухамдаа Франц улс БНМАУ-ыг 1964 онд хүлээн зөвшөөрсөн хэдий ч 1980-аад оноос л хоорондоо харилцаа холбоо тогтоосон бөгөөд 1996 оныг хүртэл Москвагаар дамжуулж Оросын нийслэлд суух элчин сайд Францыг Монголд төлөөлж байжээ³.

Гадаад Хэргийн Яамны архив 1964 оноос хойш л ийнхүү Монголын талаар өөрийнх нь гэсэн баримт сэлттэй болсон юм. Үүнээс өмнө англи, франц архивуудад зөвхөн ЗХУ, Хятад, Япон улстай холбоотой үйл явдлын хүрээнд л Монгол улсын талаар сөхөгддөг байжээ. Энэ нь ихэнхдээ олон улсын түвшинд тогтоосон хууль зүйн статустай нь авцалдаагүй байдаг бөгөөд франц-британийн архивын мэдээллүүдэд БНМАУ-ын дотоод хэргийн талаар төдийлөн өгүүлдэггүй.

Одоо байгаа бага хэмжээний бодит эх сурвалжийг баяжуулахын тулд өөр төрлийн эх сурвалжаас мэдээлэл авах шаардлагатай юм. 1921 оны үйл явдлын үеэр Монголд байсан Ф. Оссендовски⁴, Д. Перчинь⁵ зэрэг хүмүүсийн бичсэн тэмдэглэлүүд, 1926 онд

² War office, 106/5619 буюу 1934-с 1937 оны Монгол, гадаадын цөөнхийн нутаг дэвсгэр. Ихэнх дурдатгалд Японы Ар-Монгол дахь бодлогыг дурдсан байдаг. Монголын талаар өгүүлсэн зүйлд ихэнхдээ Мандчүкү, БНМАУ хоёр хоорондох хилийн асуудлыг зохицуулахаар Мандчүлид Бага хулар талаар өгүүлдэг (англи хэл)

³ 2002 оны 10 с арын 18-нд Монголын талаар хийсэн Сенатын чуулган (франц хэл)

⁴ ОССЕНДЕВСКИ /Фердинанд Антони/, Адгуус, хүн ба бурхан: Хориотой Монголоор, 1920-1921 он, Фэбюс, Парис, 1995 (франц хэл)

⁵ ПЕРЧИЭНЬ /Д/, Ар Монголын 1919-1921 оны хямралын үеийн гэрчийн тэмдэглэл, Анда соноы 39-р дугаар, 2000 оны 10 сар, хуудас 13-21, 2003 оны 47-50 дахь дугаарын 16-79-р хуудас, Д. Савели орос хэлнэс орчуулсан (франц хэл)

БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр байсан хятад туршуулуудын замын тэмдэглэлээс үүдэлтэй Ма Хо Тианы⁶ бүтээлүүд зэрэг франц, англи хэл дээр олддог баримтуудыг ашиглах боломжтой. Эдгээр материалууд нь гурван төрлийн тогтмол хэвлэлд хэвлэгдсэн байна. Үүнд: англи хэл дээрх сэтгүүлүүд, Хятадад хэвлэгдсэн баримтууд, дэлхий дахинд болж байгаа үйл явдлаар дагнасан Францад хэвлэгддэг /Франц Ази, Европын мэдээ, Олон улс улс төр, хууль эрхийн болон эдийн засгийн баримт мэдээ г.м/ сэтгүүлүүд болно. Түүнчлэн Ф. Дэссбэргийн Магистрын зэрэг хамгаалахдаа Монголын архивын баримт мэдээг ашиглаж хийсэн ажлын ачаар монгол баримт материалтай танилцах боломжтой болсон. Монголын засгийн газраас мөн /үндсэн хууль болон 1921-ээс 1981 оны статистик зэрэг/ зарим баримтыг франц хэл дээр хэвлүүлсэн. Түүнээс гадна зөвлөлтийн олон улсын бодлогын талаарх хэсэг бүтээлд БНМАУ-ын талаарх сэдвүүд байдаг. Эцэст нь хэлэхэд монгол төрийн хүний тунхаглал, Монгол Ардын намын хөтөлбөр, монголын засгийн газрын гаргасан шийдвэрүүд зэргийг Францад олж үзэх боломжтой.

Зөвлөлтийн талаар Францад олж болох баримт материалын тоо хэмжээтэй Монголын түүхийн талаарх материалуудыг харьцуулахад дэндүү ядуу бөгөөд архив, хэвлэгдсэн бүтээлүүдээс мэдээлэл хайхад “шоргоолж” шиг хөдөлмөрлөх хэрэг гарна. ЗХУ болон Монголын талаарх эх сурвалжуудын олдоц ийм ялгаатай байхад францын, цаашилбал барууны түүх судлалд хэрхэн нөлөөлөхгүй байх билээ гэж бодоход хүрнэ. Эх сурвалжгүй түүх гэж чухам байдаггүй. Монголын тухай эх сурвалжийг нэг бол Францаас олж авах хэцүү, үгүй бол Азийн хүчирхэг гүрнүүд болох ЗХУ, Хятад, Японы улс төрийн сэдэвтэй байнга уялдаж байдаг гэсэн үг.

2. БНМАУ-ын талаар франц-английн түүх судлал

1960-аад оныг хүртэл Монголын тухай хийгдсэн эрдмийн ажил гээд байх дорвитой зүйл үгүй юм: Ердөө л 1937, 1935 онуудад тус бүр бичигдсэн Левин, Дун нарын бүтээлийг нэрлэж болох юм. Ази тивд Япон, Хятад, ЗХУ-ын хооронд хурцадмал байдал бий болоод байсан тэр үед Баруунд төв азийн тэр улсад санаа зовж байсан юм. Дөнгөж 1955 онд л Ар Монголыг баруунд нээж өгсөн бүтээл гарсан юм. Энэ нь монгол хүний үндсэрхэг үзлийн тухай⁷ О. Латтиморийн бичсэн ном бөгөөд уг номондоо монголын түүхч Ү.Оногийн номын орчуулгыг багтаасан байдаг. Энэ бүтээл нь Монголын ардын хувьсгалын эцэг гэгдэх Х. Чойбалсан, Д.Сүхбаатар нарын намтрыг бүтээх гол зорилготой. Энэ номын оршилд Монголын үндсэрхэг үзлийн талаар хоёр зохиолчийн хамтран бичсэн эссээг

⁶ МА ХО ТИАН, Хятадын тагнуул Монголд, Балтиморь, Хоркин хэвлэлийн 1949 оны дугаар, хуудас 215 (франц хэл)

⁷ ЛАТТИМОРЬ /Овен/, Монгол дахь үндсэрхэг үзэл ба хувьсгал, Лейден, Е.Ж. Брилл, 1955 он, 186-р хуудас (англи хэл)

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

нийтэлжээ. Дээрх хэдэн бүтээлийг эс тооцвол Ар монгол, хожим Бүгд найрамдах Монгол Ард Улсын талаар бүтээл туурвил баруунд 1960-аад оноос л гарч эхэлсэн байна. Барууны бүтээл туурвил нь Зөвлөлт-Монголын түүх судлалд судалгааны шинэ сэдвүүд гарч ирэх эсэхээс хамаардаг. Томас Эвингийн хэлсэнчлэн 1960-аад оноос орос, хятад, монгол хэл дээрх материалын эх үүсвэр олж авах бололцоотой болсон учраас монголын талаар бүтээл туурвил бичих боломж барууны орнуудад нээгдсэн юм⁸. Бүгд Найрамдах Монгол Ард Улс НҮБ-д орсноор социалист бус дэглэмтэй орнуудад нээлттэй болж илүү их анхааралд өртөх болсон тул 1960-аад оныг эргэлтийн он жил гэж хэлж болно. Барууны судлаачид Монголд эхнээсээ ирцгээв. Тэдний дунд Франц, Их Британийн судлаачдаас Ф. Аубин, Р. Хамион, С. Хюмфрей нарыг нэрлэж болно. Үүний ачаар Европ, Америкт⁹ /ар, өвөр/ Монгол судлалын олон төвүүд бий болж “монголч” эрдэмтэд төрөн гарч эхэлсэн юм. Монголч эрдэмтдийн анхдугаар чуулган 1959 онд болсон бол хоёрдугаар чуулган нь 1971 онд болж, энэ үеэр өнгөрсөн арваад жилд судалгаа хийсэн сэдвүүдийнхээ талаар дүгнэж хэлэлцжээ. Францад бас Лүйс Хамбис Өндөрлөгийн Азийн¹⁰ талаар ажиллаж, Францын Коллежид /Монголоор ШУ-ны Академи/ судалгааны ажлаа танилцуулжээ.

Мөн энэ л арваад жилийн хугацаанд Р.Рюпен, О. Латтимор нар тус тус *Хорьдугаар зууны Монгол* /1966/, *Монгол улс, нүүдэлчид болон комиссариуд* /1962 онд англиар, 1966 онд францаар/ бүтээлүүдээ гаргасан нь олонд их хүртээлтэй болжээ.

Монголыг дахин ингэж сонирхох болсноор барууны судалгааны төвүүд монголын судлаачидтай тогтмол холбоотой байж, бүтээлээ хэвлэн гаргахад нь тогтмол хувь нэмрээ оруулдаг байна. Ийнхүү монгол судлаачдын нийтлэл, бүтээлүүдийнх нь анхны орчуулгууд барууны мэргэшсэн хэвлэл нийтлэлд өргөнөөр хэвлэгдэж эхэлсэн юм. Ийнхүү гадаадын судалгааны төвүүд Монголд эхлүүлсэн судалгаануудын мөрөөр орж олонд таниулах ажлыг хийсэн бөгөөд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүхийг 1976 онд Харвардын Их сургуульд анх англи хэлнээ хөрвүүлжээ. Гэвч, 1960-аад оны үеийн ч бай, ер нь Монголын талаарх бүтээлүүд нь эссэний төрөлд хамарна, яагаад гэвэл эдгээр бүтээлийг Монголын архивын мэдээ баримт ашиглаж нухацтай хийгээгүй юм. Энэ бол

⁸ Евинг /Э. Томас, Алх хадуур хоёрын завсар уу? 1911-1921 оны Орос, Хятадын Ар Монгол дахь бодлого, Урали болон Алтай Индиана их сургууль, Денис Синор, 1980 он, танилцуулга (англи хэл)

⁹ 1916 онд байгуулагдсан Их Британийн африк болон дорнын судлалын сургуульд ойрогхоноос л Монгол судлалын төв нээгдсэн. Харин Кэмбрижийн их сургуульд үндэслэн Овен Латтиморийн 1969 байгуулсан Англи-Монгол судлалын нийгэмлэг нь Монголын талаарх асуултуудад хариулт өгөх гол газрын нэг юм. АНУ-ийн олон их сургуульд Азийн чиглэлийн судалгааны төвүүд байдаг. Тэдгээрээс хамгийн алдартай бөгөөд сайн ажилладаг нь Индианагийн “Монгол судлал”-ын төв юм. Оклахамагийн их сургуульд бас судалгааны нэг төв байдаг бөгөөд “Төв Азийн судалгааны сэтгүүл” нэртэй хэвлэлийг тогтмол гаргадаг. Итали, Франц, Дани, Шведэд бас энэ төрлийн сэтгүүлүүд гардаг. Францад Сибирь, Монголын судалгааны төв байгуулагдаад 30-аад жил болж байгаа юм.

¹⁰ Азийн тэгш өндөрлөг хэсгийг илэрхийлдэг газар зүйн ухагдахуун.

Социалист дэглэмтэй улсууд болон барууны орнуудын харилцаа сайжирч байсан үе бөгөөд хоёр өөр үзэл баримтлалтай энэ хоёр бүлэг улсууд харилцан нээлттэй болсон хэдий ч эдийн засаг, улс төр, соёлын хоорондын тэмцэлийн хүчин саараагүй байсан юм. Ийнхүү ихэнх бүтээл туурвилд Монголыг ЗХУ-ын дагуул мэтээр үзэж байсны жишээ нь Стоплины Францад гаргасан ном юм¹¹.

Овен Латтиморийн бичиж, 1966 онд франц хэлнээ орчуулагдсан ном болон Стоплины бүтээлд хариу болгож Джек Леграндын 1975¹² онд бичсэн ном нь “дагуул” хэмээх энэ үзлийг Францад үгүйсгэсэн хоёр бүтээл юм. Энэ хоёр бүтээлд Монголын эрх ямбатнуудын хуйвалдаан, 20-р зууны эхэн үеийн Манжийн дарангуйллын эсрэг жирийн малчин ардын тэмцэл нь нэг ёсондоо үндэсний болон нийгмийн гэсэн салшгүй хоёр шинжийг агуулж байсныг өгүүлдэг юм. ЗХУ-тай холбоо тогтоосон нь захиргаанд нь орсон бус хятадын дарангуйллаас чөлөөлөгдөж улам хүчирхэгжиж байсан Японы нөлөөнөөс дайжихын тулд хийсэн чөлөөт сонголт байсан юм. Джек Леграндын “Монголын сонголт” хэмээх бүтээлийн нэр нь түүхэн энэ асуудлыг өгүүлж буй юм. Тийм ч болохоор монголын түүхч Н. Далай “Бид Оросыг сонгосон, тухайн үедээ тэр нь маш ухаалаг сонголт байсан юм” гэж өгүүлсэн байх¹³. Орчин үеийн Монголын түүхийг энэ талаас нь авч үзвэл тэр үеийн ЗХУ, Монгол улс хоёр нэгэн ашиг сонирхолтой байсныг харуулж Францын түүх судлалд эргэлт хийж болох талтай.

Францад өнөөг хүртэл ихэнх түүхэн бүтээлүүдийг туурвихдаа жинхэнэ эх бүтээлүүд ашиглалгүй англи, франц хэл дээрх бүтээлүүдийг найруулан бичдэг байсан нь маш учир дутагдалтай. Зөвхөн дээр дурдсан Ф.Дэссберг монгол эх сурвалж ашиглаж, Джек Легранд монгол номууд ашигласан байна. Түүнээс гадна хэдэн монгол зохиолчдын¹⁴ франц хэл дээр хэвлэгдсэн бүтээлүүдийг нэрлэж болно. Түүнээс гадна ихэнх нь түүхчидийн бүтээл биш байдагийн сацуу Монголын талаар ажиллаж байгаа ихэнх оюутан судлаачид угсаатны зүй судлал, социологийн судлал хийдэг. Тэгэхлээр орчин цагийн Монголын, ялангуяа 20-р зууны эхний хагасын түүх Францад судлагдаагүй гэж хэлж болно.

¹¹ Стоплин,, 1971 он (франц хэл)

¹² Ж. Легранд, Монголын сонголт, нийгмийн хэвлэл, Парис хот, 1975 он, 287- хуудас (франц хэл)

¹³ 2003оны нэгдүгээр сард Арте сувгаар гарсан Керстин Маурсбергер, Ц. Батмөнх нарын “Уламжлал, капитализм хоёрын хоорондох Монгол” кинонд гардаг (франц хэл)

¹⁴ Базарын Ширэндэвийн “Монголд ардын хувьсгал гарч БНМАУ байгуулагдсан нь, ЗХУ-ын ШУ-ны Акамеми, Москва 1965 он; Б. Ширэндэвийн “Капитализмыг алгассан Монголын туршлагаар”, Улаанбаатар, Улсын хэвлэлийн газар, 1968 он, 118-р хуудас; Сандагийн “Монголын ард түмний улс төрийн тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, шинэ амьдралын бүтээн босголт, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1966 он, 135-р хуудас (франц хэл)

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

Монгол улс Баруунд нээлттэй болж, судалгааны төвүүд байгуулагдсан хэдий ч бодит эх сурвалж дутагдалтайн дээр өөр өөр үзэл бодолтой хоёр бүлэг улсууд соёл урлагийн тавцанд бас зөрчилтэй байсан нь Монголын тухай бүтээлүүд туурвил хийхэд нөлөөлж байна. Ийнхүү дутуу дулимаг мэдлэг нөхцөл байдалд нөлөөлж Ази судлалд францын судлаачдын ашигладаг дэд бүс нутагт хуваах аргыг хэрэглэхдээ Монгол улсыг аль хэсэгт нь хамруулахаа сайн мэдэхгүй байна гэсэн үг үү? Эсвэл энэ орны талаар ийнхүү дутуу дулимаг мэдлэгтэй байдаг нь түүнийг судалгааны шинэ ухагдахуунд оруулж судлах явцад өдийг хүртэл саад болсоор ирсэн юм болов уу? Тэгвэл тэр шинэ ухагдахууныг гаргаж ирэх шаардлагатай.

3. Францын судалгааны талбарт Монголын эзлэх байр суурь, түүний ЗХУ-тай тогтоосон харилцаа

Францын оюутан судлаачид чухамдаа Азийг газар зүйн хувьд дэд бүс нутагт хуваадаг бөгөөд Монгол үүнд нь огт багтдаггүй.

Газар зүйн хувьд Монгол нь Өндөрлөгийн Ази хэмээх геологийн тогтоцийн бүрэлдэхүүнд багтдаг. Төв Ази нь Энэтхэг, Сибирийн хооронд орших бөгөөд дөрвөн зүгтээ уулархаг нуруудаар хүрээлэгддэг. 1965-аас 1977 онуудад Францын Коллежид Төв Азийн түүх, орон судлалын багш, Төв болон Өндөрлөгийн Ази судлалын төвийн захирал байсан Лүйс Хамбис энэ талаар судалгааг хийсэн байна. Тэрээр бас монгол хэлний нэг дүрмийг зохиосон хүн юм.

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД



Монгол улс баруун талаараа Төв Азийн нийт газар нутагтай зэрэгцэн оршино. Төв Ази нь урд болон зүүн талаараа Гималай болон Памирын нуруудаар хүрээлэгдэнэ. Гэвч тухайн үеийн газар нутгийн энэ хуваарилалт нь одоогийн Төв Ази хэмээх ойлголтын зарим хэсгээс л бүтнэ. Барууны орнуудад Төв Ази гэдгийг Каспийн тэнгис, Тиан Чаны уулсын (одоогийн Таджикистан/ хоорондох газар нутаг буюу 1991 оноос тусгаар тогтносон Казахстан, Киргизстан, Узбекистан, Таджикистан, Туркменстан хэмээх таван Бүгд Найрамдах улсаас бүрддэг гэж ойлгодог.

Зарим судлаачид Төв Азийн талаар судалгаа хийхдээ Ар Монгол буюу Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг оруулдаг. Төв Азийн түүх, соёл иргэншлийн судалгааны бүтээлдээ¹⁵ Роукс Монголыг оруулсны учир нь удаан он жилийг хамарсан соёл иргэншлийн тухай бүтээл байсанд оршино. 1993 онд Франсуаз Аубин Монголыг Төв Азид багтаан авч үзжээ. Тэгээд:

Монгол улс бол олон арван жилийн өмнөөс дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн соёл болон улс төрийн орон зай бөгөөд Турк, Иран, Лалын ертөнцөөс бараг бүрмөсөн ангид Төв Азийн цорын ганц орон зай юм гэж онцолжээ¹⁶.

Монгол улс өмнө болон зүүн талаараа Барууныхны нэрлэдэгээр Алс-дорнодтой хил залгана. “Алс дорнод” хэмээх ойлголт хичнээн хувьсан өөрчлөгдсөн ч 19, 20-р зууны

¹⁵ Роукс /Жон-Павел/, Төв Ази, Парис, Фаяард хэвлэлийн газар, 1997 он, 5-9-р хуудас (франц хэл)


¹⁶ Аубин /Франсуаз/ “Чингис хааныг эрхэмлэх үзлийн дахин сэргэлт ба коммунизмын дараах Монголын үндсэрхэх үзэл”, Дорнод Газар Дундын тэнгис болон турк-иранийн ертөнцийн судалгааны дэвтэр, дугаар 16, 1993 оны 7-12 сар, хуудас 137-206 (франц хэл)

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

туршид Хятад, Япон, Солонгос улсууд үүнд үргэлж багтсаар ирсэн бөгөөд Зүүн азийн судлалд өнөө ч гэсэн энэ хэвээр байна. Монгол харин үүнд дандаа багтаад байдаггүй.

Spatialisation des mots occidentaux de l'Asie.

Азийн баруунаас
гаралтай үгсийг
сансраас харахуй



Source: pelletier (Philippe) (dir.), *Géopolitique de l'Asie*, Paris, Nathan, 2006, p.31.

Монгол улс тэгэхлээр газар зүй, соёл, улс төрийн талаасаа нилээн сайн тодорхойлогдсон бүс нутгуудын тэг дунд оршдог бөгөөд судалгааны төрлийн онцлогоос хамаарч алинд нь ч харьяалагдах боломжтой аж. Элиссээфийн хэлсэн нь:

Шинж чанар, хэлбэр, газар зүйн байдал, эдийн засаг, ниймэг, соёлын амьдралаараа Монгол улс Гималай, Саян-Алтай, Памирын нуруунууд болон Хянганы уулсын дунд орших Монгол улс нь Азийн Хинтерландын¹⁷ төвд оршдог¹⁸.

¹⁷ Үгчилвэл: бөглүү газар

¹⁸ Элиссээф/В/, Аубин /Ф/, "Монгол улс-түүх", Универсалис нэвтэрхий толь, СИДИ-РОМ, 2003 он (франц хэл)

Ийм онцлогтой Ар Монгол улс буюу хожмын Бүгд Найрамдах Монгол Ард Улс энэ тохиолдолд ЗХУ, Хятад, Япон улсуудын үүсгэсэн дорнын гурвалжингийн төвд орших стратегийн шинжтэй. Гэхдээ Монгол улсыг ер нь эдгээр гурван орны гадаад бодлоготой л холбон судлах боломжтой. Тиймээс Францаас Ази дахь Монголын олон улсын харилцаа, ялангуяа ЗХУ-Хятад-Японы гурвалжин дахь харилцаа холбооны хувьслыг судлах боломжтой мэт санагдаж магад. Энэ л үүднээс Зөвлөлт Монголын харилцааг судлах нь хэрэгтэй юм.

Өнөө үед Францад энэ сэдвээр судалгаа хийгдээгүй бөгөөд ихэнх салбарт Зөвлөлт Монголын харилцааг ЗХУ-аас Монголд үзүүлж байсан дарангуйлал мэт үздэг¹⁹.

1960 оныг хүртэл Монгол улс Азийн хоёр хүчирхэг гүрний дунд бай болох үед л ихэвчлэн Монголыг судалдаг байв. Хожим Барууны орнууд болон социалист дэглэмтэй орнуудын хоорондох харилцаа сайжирч Монгол нээлттэй болж, тус улсын талаар судалгааны ажлууд хийгдэж эхэлжээ. Гэвч угсаатны болон социологи судлалын нэг л чиглэл дээр төвлөрсөөр байгаа билээ. Түүхчид тус улсын орчин цагийн түүх дээр ажиллах нь ховор бөгөөд ажиллаа гэхэд Монголыг ЗХУ-ын дагуул байсан гэж зарлахаас биш бодит эх сурвалж /архив/-тай төдийлөн ажилладаггүй.

Англи, Францад Азийн гурван хүчирхэг гүрэн /ЗХУ, Хятад, Япон/-ний гадаад бодлоготой холбоотой материалд л Монголын тухай өгүүлдэг болохоор орчин цагийн Монголын талаар судалгаа эхэлсэн франц судлаачид дандаа тодорхой бус байдалтай тулгардаг.

Ийм тодорхой бус байгаа нь Монголыг Ази судлалаар дамжуулж, тэр тусмаа ЗХУ, Хятад, Японы үүсгэсэн гурвалжныг судлах замаар судлах шаардлагатай байдагтай холбоотойн сацуу архивын материалуудыг ангилсан байдалтай холбоотой бөгөөд Монголыг тусад ангилж байрлуулах шаардлагатай. Гэвч ЗХУ-ын Хятад, Япон зэрэг Азийн улсуудын шунахай сэтгэлээс өөрийгөө хамгаалах анхан шатны “халхавч” болж байсан улсуудыг судлах судалгааны шинэ талбар гарч ирж болно. Энэ нь Номхон далайн орнууд, Алс-Дорнодоос Төв Азийн Зөвлөлт социалист бүгд найрамдах улсыг хамрах орон зай юм.

Төв Ази, Сибирь, Монгол, Зүүн хойд Азийн зураг

¹⁹ Франц хэл дээрх бүтээлүүд; Дэссберг /Фредерик/, Монгол дахь Орос, Зөвлөлтийн бодлого /1911-1924 он/; КЕРГАНТ /Арманд/, “Монгол дахь Хятад ба Орос” ; Ж.ЛЕГРАНД, Оросын Монголын ард түмний үндсэний хөдөлгөөн, 1921 оны Ардын Хувьсгал; Б.НИКИТИН, “Монголын олон улсын статус” ; СТОПЛИН/Аркади/, Москва ба Бээжингийн дундах Монгол; П.ВОСТОКОВ, “ЗХУ, Монгол ба Шинжиан”

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД



Ямартай ч гэсэн Зөвлөлт, Монголын харилцааны талаарх судалгаа нь Францын хувьд бараг цоо шинэ талбар бөгөөд үүний тулд Монгол, Зөвлөлтийн талаарх эх сурвалжийн аль алиныг ашиглах шаардлагатай. Гэвч эдгээр сурвалжууд нь илүү өргөн цар хүрээтэй орчуулагдаж гарахгүй л бол Францаас олж танилцах боломжгүй.